

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 04 дүгээр сард хийсэн ажлын товч мэдээ

2023 оны 4 дүгээр сарын 27

Дархан-Уул аймаг

Тус алба 5 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, хяналт шалгалт хийхэд хүний нөөцийн дутагдалтай ажиллаж байна. Тус албаны дотоод аудиторын сул орон тоонд төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай зарыг зарыг байгууллагын цахим хаягаар мэдээллэхэд албан хаагч шилжиж ирээгүй болно. Дотоод аудиторын 3 сул орон тоонд Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлөөс тусгай шалгалт зарлагдсан ба хугацаа болоогүй байна.

Сангийн сайдын 2023.03.24-ны өдрийн СХШ/02 дугаартай нэгдсэн удирдамж болон аймгийн Засаг даргын 2023.03.24-ний өдрийн 23-06-23/04 удирдамжийн хүрээнд Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны санхүү, төсвийн гүйцэтгэл, үйл ажиллагаа, сангуудад хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж 9,214.2 мянган төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлэхээр, 1,000.0 төгрөгийг иргэдэд нөхөн олгуулахаар Улсын ахлах байцаагчийн акт тогтоож, хөрөнгийг бүртгэлд тусгуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлээ.

Засгийн газраас авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн Засаг даргын 2023 оны 01-А/60 дугаар захирамжаар албаны дарга Шүүр ажиллагааны хяналт шалгалтын ажлын хэсгийн гишүүнээр томилогдон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 13 газарт ажилтны авилга, албан тушаалын томилгоотой холбоотой хяналт шалгалт хийж, тайланг ажлын хэсгийн ахлагчид хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2023 оны 1-р улирлын байдлаар дотоод аудит хийж байна. Шилэн дансны цахим хуудас шинэчилсэнтэй холбогдуулан 1-р улирлын тайлангийн хугацааг Сангийн яамнаас 2023.05.01 хүртэл хойшлуулсан.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 1-р улиралд хийсэн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын дүнг бэлтгэн боловсруулж, Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн холбогдох хорооны хурлын тогтоолыг гаргууллаа.

Тус албанд ирүүлсэн хугацаатай мэдээ тайланг холбогдох газарт нь хугацаанд хүргүүлээ. Үүнд:

- Тус албанд ажиллаж буй албан хаагчдыг төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах нийтлэг шаардлагын дагуу Эрүүгийн хуульд заасан авлига албан

тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгэл эдэлж байгаагүй эсэх лавлалааг Аймгийн Цагдаагийн газраас авч албан бичгээр АЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн.

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 3 дугаар сарын байдлаар гарган АЗДТГ-ын СТСХ-т цахимаар хүргүүлсэн.

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж байгаатай холбогдуулан дотоод аудитын нэгжийн тайлан болон холбогдох судалгааг гаргаж Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлээ.

- Дотоод аудиторын сул орон тооны сонгон шалгаруулалтад тэнцсэн албан хаагчийн ХАСУМ-ыг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Сургалт, хэлэлцүүлгийн талаар:

- MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага сургалтад 2 албан хаагч;

- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ийг хэрэгжүүлэх төрийн албан хаагч, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь" богино хугацааны сургалтад 2 албан хамрагдан сертификат авсан;

- Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зөвлөлийн ажлын албанаас зохион байгуулсан сургалтад 1 албан хаагч;

- Нийтийн мэдээллийн тухай ил тод байдлын тухай хуулийн сургалтад 1 албан хаагч;

- Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих 7:4:10 цахим сургалтад 5 албан хаагч

- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдрийг угтан зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд 5 албан хаагч:

- ММНБИнститутийн Дархан салбарын 2023 оны бүх гишүүдийн хуралд 3 албан хаагч;

- Монгол Улсын ЗГХЭГ-аас Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн хүрээнд зохион байгуулсан иргэдээс санал авах хэлэлцүүлэгт 5 албан хаагч тус тус хамрагдаж саналаа хүргүүлээ.

- Ахмадаа сонсъё-Иргэдийн индэр уулзалт хэлэлцүүлэгт тус албанаас өндөр насны тэтгэвэрт гарсан 2 өндөр настан оролцсон. Албаны дарга аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2 удаа оролцсон.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА